



**МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2011 оны “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 276 дугаар тушаалын хавсралтын Өлзийбатын Баттулгатай холбогдолтой хэсгийн “Сангийн яам” гэснийг “Монголбанк”, 2010 оны “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах тухай” 391 дугаар тушаалын Ганболдын Батчимэгтэй холбогдолтой хэсгийн “Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Мюнхений Техникийн их сургуулийн” гэснийг “Австрали Улсын Вестерн Сидней их сургуулийн”, 2009 оны “Гадаадад зээлээр суралцуулах тухай” 268 дугаар тушаалын Бүрэнтогтохын Жаргалантай холбогдох хэсгийн “магистрантурт 2 жилийн хугацаагаар” гэснийг “докторантурт 3 жилийн хугацаагаар” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБЯАР